



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БӨА-2022/18/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Ж.Назгүл Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА А.ОЗАТ ТАНАА

2022.08.25 № 169
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн байдлын тайлангаар үндсэн хөрөнгийн дансанд 2021.3 сая төгрөгийн, бараа материалын дансанд 11.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийхдээ 1977.7 сая төгрөгийн хөрөнгийг тоолж, 39.2 сая төгрөгийн хөрөнгийг дутуу тоолж хөрөнгийн үлдэгдлийг тооллогын бүртгэлийн дүнг санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь заалт болон иж бүрэн байх, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,184,640.00</u>	<u>11,184,640.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	9,184,640.00	11,184,640.00
354	Хангамжийн материал	9,184,640.00	11,184,640.00
35420	Аж ахуйн материал	7,761,000.00	9,761,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,423,640.00	1,423,640.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,237,352,335.85</u>	<u>1,210,948,596.13</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,237,352,335.85	1,210,948,596.13
392	Биет хөрөнгө	1,230,460,335.85	1,204,056,596.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,037,601,033.56	1,046,701,033.56
39202	Хуримтлагдсан элэгдэл	(201,707,148.84)	(259,174,656.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	197,290,000.00	197,290,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(144,183,124.81)	(162,800,624.77)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	328,057,988.00	327,977,980.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(155,386,144.94)	(173,968,286.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,746,428.00	40,848,820.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,340,772.79)	(14,828,758.15)
39209	Зам, гүүрийн байгууламж	191,503,959.00	267,703,144.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(120,520,711.04)	(139,646,523.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	125,664,351.13	131,664,351.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	(46,661,421.42)	(58,105,783.62)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	395,900.00	395,900.00
393	Биет бус хөрөнгө	6,892,000.00	6,892,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,752,947.00	8,752,947.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,860,947.00)	(1,860,947.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,246,536,975.85</u>	<u>1,222,133,236.13</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,246,536,975.85</u>	<u>1,222,133,236.13</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,246,536,975.85	1,222,133,236.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	452,639,918.40	452,639,918.40
51101	Өмч: - төрийн	452,639,918.40	452,639,918.40
512	Хуримтлагдсан үр дүн	550,145,589.89	525,741,850.17
51210	Өмнөх үеийн үр дүн	550,145,589.89	550,145,589.89
51220	Тайлант үеийн үр дүн		(24,403,739.72)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	243,751,467.56	243,751,467.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,246,536,975.85</u>	<u>1,222,133,236.13</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	703,935,597.00	485,256,680.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	703,935,597.00	484,756,680.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	310,792,271.00	94,199,185.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	310,792,271.00	94,199,185.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,313,026.00	3,310,995.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,313,026.00	3,310,995.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	383,830,300.00	387,246,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	383,830,300.00	387,246,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	516,172,164.62	509,071,419.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	516,172,164.62	509,071,419.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	516,172,164.62	506,999,719.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,372,623.29	251,430,600.00
210101	Үндсэн цалин	164,731,553.29	175,350,928.00
210102	Нэмэгдэл	49,646,370.00	45,629,369.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	116,000.00	
210105	Гэрээт ажлын хөлс	24,878,700.00	30,450,303.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,123,200.00	32,552,700.00
210201	Тэтгэврийн даатгал	22,860,500.00	22,907,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,958,100.00	2,411,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,018,600.00	1,929,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	480,600.00	482,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,805,400.00	4,822,600.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,056,400.00	23,127,100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,190,800.00	1,164,800.00
210302	Түлш, халаалт	23,865,600.00	21,962,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,670,876.00	12,586,145.00
210401	Бичиг хэрэг	2,631,300.00	2,246,600.00
210402	Тээвэр, шатахуун	16,174,676.00	9,068,645.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,864,900.00	1,182,900.00
210404	Ном, хэвлэл		-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		88,000.00
2105	Нормативт зардал	458,300.00	457,000.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	458,300.00	457,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	433,400.00	1,176,000.00
210604	Урсгал засвар	433,400.00	1,176,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,978,876.71	2,739,800.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1,978,876.71	2,739,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,645,000.00	1,263,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	201,100.00	150,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	427,600.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	213,900.00	178,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	458,100.00	398,700.00
210807	Газрын төлбөр	45,600.00	37,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	94,800.00	31,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194,433,488.62	181,666,574.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,854,650.00	47,552,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	132,028,838.62	133,613,924.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,071,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,071,700.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,071,700.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>187,763,432.38</u>	<u>(23,814,739.72)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,115,755.04	589,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,115,755.04	589,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,115,755.04)	(589,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>184,647,677.34</u>	<u>(24,403,739.72)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	452,639,918.40	243,751,467.56	550,145,589.89		1,246,536,975.85
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	452,639,918.40	243,751,467.56	550,145,589.89		1,246,536,975.85
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн					-
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	452,639,918.40	243,751,467.56	550,145,589.89		1,246,536,975.85
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	452,639,918.40	243,751,467.56	550,145,589.89		1,246,536,975.85
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	452,639,918.40	243,751,467.56	550,145,589.89		1,246,536,975.85
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүдэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			(24,403,739.72)		(24,403,739.72)
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	452,639,918.40	243,751,467.56	525,741,850.17		1,222,133,236.13

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>393,143,326.00</u>	<u>390,557,495.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	393,143,326.00	390,557,495.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,313,026.00	3,310,995.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,313,026.00	3,310,995.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	383,830,300.00	387,246,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	383,830,300.00	387,246,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>384,143,326.00</u>	<u>377,457,495.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	384,143,326.00	377,457,495.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	384,143,326.00	375,385,795.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,059,423.29	251,430,600.00
210101	Үндсэн цалин	161,116,851.38	169,924,200.00
210102	Нэмэгдэл	52,947,871.91	50,397,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	116,000.00	
210105	Гэрээт ажлын хөлс	24,878,700.00	31,109,300.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,436,400.00	32,552,700.00
210201	Тэтгэврийн даатгал	22,825,600.00	22,949,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,402,600.00	2,403,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,922,200.00	1,912,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	480,600.00	550,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,805,400.00	4,737,700.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,056,400.00	23,087,100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,190,800.00	1,164,800.00
210302	Түлш, халаалт	23,865,600.00	21,922,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,147,876.00	13,016,395.00
210401	Бичиг хэрэг	2,631,300.00	2,247,600.00
210402	Тээвэр, шатахуун	16,651,676.00	9,497,895.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,864,900.00	1,182,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		88,000.00
2105	Нормативт зардал	458,300.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	458,300.00	457,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	433,400.00	1,176,000.00
210604	Урсгал засвар	433,400.00	1,176,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,978,876.71	2,739,800.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1,978,876.71	2,739,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,645,000.00	1,302,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	201,100.00	150,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	427,600.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	213,900.00	178,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	458,100.00	398,700.00
210807	Газрын төлбөр	45,600.00	37,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	94,800.00	70,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,927,650.00	49,623,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,377,650.00	49,123,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,071,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,071,700.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,071,700.00
213504	Хөрөнгийн		
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>9,000,000.00</u>	<u>13,100,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,000,000.00	13,100,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,000,000.00	13,100,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,000,000.00	13,100,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,000,000.00	13,100,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(9,000,000.00)</u>	<u>(13,100,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-</u>	<u>-</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	387,246,500.00	385,174,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	387,246,500.00	385,174,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	387,246,500.00	385,174,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	256,430,600.00	254,358,900.00

210101	Үндсэн цалин	175,324,200.00	173,252,500.00
210102	Нэмэгдэл	50,397,300.00	50,397,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	30,709,100.00	30,709,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,552,700.00	32,552,700.00
210201	Тэтгэврийн даатгал	22,907,500.00	22,949,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,411,300.00	2,403,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,929,000.00	1,912,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	482,300.00	550,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,822,600.00	4,737,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,087,100.00	23,087,100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,164,800.00	1,164,800.00
210302	Түлш, халаалт	21,922,300.00	21,922,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,000,500.00	12,000,500.00
210401	Бичиг хэрэг	2,247,600.00	2,247,600.00
210402	Тээвэр, шатахуун	8,482,000.00	8,482,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,182,900.00	1,182,900.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	88,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	457,000.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	457,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,176,000.00	1,176,000.00
210604	Урсгал засвар	1,176,000.00	1,176,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,739,800.00	2,739,800.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	2,739,800.00	2,739,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,302,800.00	1,302,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,400.00	150,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	302,200.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,900.00	178,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	398,700.00	398,700.00
210807	Газрын төлбөр	37,300.00	37,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	70,000.00	70,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,500,000.00	57,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,000,000.00	57,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	387,246,500.00	385,174,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	387,246,500.00	385,174,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	387,246,500.00	385,174,800.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	21.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21.00	21.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8.00	8.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2.00	2.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,310,995.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,310,995.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,310,995.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,310,995.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,310,995.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,310,995.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,310,995.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,310,995.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алтай сумын Засаг даргын тамгын газрын зорилго нь: “Монгол Улсын Засгийн газрын бодлого шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэх хуулиар олгогдсон эрх үндсэн чиг үүргээ биелүүлэхэд ЗДТГ-ын үйл ажиллагааг чиглүүлж орон нутгийн тулгамдсан зорилтуудыг шийдвэрлэх, хуулиа дээдэлж, сурталчлах ажлыг зохион байгуулахад чадварлаг боловсролтой хүнд сурталгүй, хөнгөн шуурхай үйлчилгээтэй ил тод, нээлттэй байдлыг эрхэмлэсэн тэргүүний төр захиргааны байгууллага болох. Захирагчийн албаны санхүүгийн тайлангийн зорилго нь тус байгууллагын бүх хөрөнгө, эх үүсвэр, өр төлбөрийг багтаасан санхүүгийн нэгдсэн дүр зураг, тус салбарын санхүүгийн үйл ажиллагааны талаарх үнэн зөв мэдээллийг Сангийн яам, Аудитын газар, Төрийн сангийн хэлтэс, олон нийтэд хүргэх явдал юм”

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба ажилладаг бөгөөд тайлант онд тус байгууллагад шалгалт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт хөрөнгийн 516.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24.4 сая төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	9,184.6	11,184.6	2,000.0
Үндсэн хөрөнгө	1,237,352.3	1,210,948.6	-26,403.7
Нийт хөрөнгө	1,246,537.0	1,222,133.2	-24,403.7
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,246,537.0	1,222,133.2	-24,403.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,246,537.0	1,222,133.2	-24,403.7

Мөнгөн хөрөнгө, авлагын данс үлдэгдэлгүй байна. Бараа материалын дансны үлдэгдэл 11.2 сая төгрөг болж 2.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр нийт 26.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 24.5 сая төгрөгийн материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1210.9 сая төгрөг болж 26.4 сая төгрөгөөр буурсан нь Орон нутгийн давсан хэсгийн хөрөнгөөр 4.1 сая төгрөгийн Ахмадын байрны халаалтын засварын ажил, 6.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 0.8 сая төгрөгийн тавилга, 2.0 сая төгрөгийн замын тэмдгийг орлогод авч данс бүртгэлд бүртгэсэн байна.

Сумын Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 9.0 сая төгрөгийн багийн Засаг дарга нарт эд хогшил авч данс бүртгэлд тусгасан байна. Сумын Орон нутгийн хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 5.0 сая төгрөгийн гүүрийн засварын ажил, 76.2 сая төгрөгийн явган хүний зам, 4.0 сая төгрөгийн замын тэмдэг хийгдэж үнэгүй авсан хөрөнгөөр данс бүртгэлд тусгасан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 133 дугаар тогтоолоор нийт 6.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1.7 сая төгрөгийн тавилга эд хогшил, нийт 8.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор Эрүүгийн анхан шатны шүүхийн 2019 оны 2020/ШЦ/07 дугаар шийтгэх тогтоолоор ЗИЛ-131 маркийн автомашиныг улсын орлого болгосныг ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэгдсэн бөгөөд тайлант онд тус автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар 0.5 сая төгрөгөөр худалдаж данснаас хассан байна.

Тайлант хугацаанд өр төлбөр гараагүй байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1222.1 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 24403.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус Засаг даргын тамгын газрын 2021 оны анх батлагдсан төсөв 316.9 сая төгрөг, тодотгосон төсөв 327.4 сая төгрөг байна.

Анх баталсан төсвийг 10.5 сая төгрөгөөр бараа үйлчилгээний бусад зардлын төсвийг нэмж тодотгон баталжээ. Алтай сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 16 дугаар тогтоолоор орон нутгийн орлогын давсан хэсгээс 44.5 сая төгрөгийг төсөл арга хэмжээний зардалд хуваарилсан байна.

Тайлант онд аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс цалингийн зардлын төсвийг 15.3 сая төгрөгийн цалингийн нэмж тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 387.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 385.2 сая төгрөгийг зарцуулж, цалингийн зардлын төсвийг 2.0 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Сумын Орон нутгийн орлогын давсан хэсгээс баталсан 44.5 сая төгрөгийг 17 төсөл арга хэмжээнд зарцуулсан байна.

Нийт төсвийн 66.4 хувийг цалин, 8.4 хувийг НДШ-ийн зардал, 6.0 хувийг тогтмол зардал, 3.2 хувийг хангамж бараа материалын зардал, 0.1 хувийг норматив зардал, 0.3 хувийг урсгал засварын зардал, 0.7 хувийг дотоод томилолтын зардал, 0.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 15.0 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс хяналтын зардалд 1.4 сая төгрөгийг, Статистикийн хэлтсээс 1.5 сая төгрөгийг мал тооллогын зардалд, аймгийн Засаг даргын захирамжаар Тэргүүний сумын шагналд 0.2 сая төгрөгийг, Хүүхэд, гэр бүл хөгжлийн төлөө төвөөс 0.2 сая төгрөгийг эмзэг бүлгийн хүүхдүүдэд, нийт 3.3 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна. Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд нийт 387.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 385.2 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 2.0 сая төгрөгийг цалингийн зардлын батлагдсан төсвөөс буцаан төвлөрүүлжээ.

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтад хамаарах байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь буюу 7.5 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, тогтоолын 1.4-д заасныг зөрчиж бараа үйлчилгээний бусад зардлаас 11.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд нийт 387.2 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 387.2 сая төгрөгийн 146 мэдээллийг ил тод байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Шилэн дансны мэдээлэл байршуулсан байдал 97.9 хувьтай байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудад нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан 11.8 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийн биелэлтийг Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 07-р сарын 06-ны өдрийн 48 тоот албан бичгээр ирүүлжээ.

Зөвлөмжийн биелэлтийг давтан шалгаж үзэхэд шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулж, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгаж зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 57.8 сая төгрөгийн зөрчил илэрч, албан шаардлага хүргүүлэв

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 57.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Алтай сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд гүйцэтгэлээр 385.2 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 2.0 сая төгрөгийг цалингийн зардлын батлагдсан төсвөөс буцаан төвлөрүүлжээ.

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтад хамаарах байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь буюу 7.5 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, тогтоолын 1.4-д заасныг зөрчиж бараа үйлчилгээний бусад зардлаас 11.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" 1.4-т "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

2. Сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/20 дугаар тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсгийг байгуулж ажиллуулсан байна. Санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийн дансанд 2021.3 сая

төгрөгийн, бараа материалын дансанд 11.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийхдээ 1977.7 сая төгрөгийн хөрөнгийг тоолж, 39.2 сая төгрөгийн хөрөнгийг дутуу тоолсон, тооллогын бүртгэлийн дүнг санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2-т “хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”,

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана”, 1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-ээс 31-ний дотор/, 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/,” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийг дахин хянаж, үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулж, зөрчлийг арилгаж ажиллах талаар албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алтай сумын ЗДТГ	2	57.8					2	57.8		